

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

Г.ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙ								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Очир баригч	76.16.490	1	Өргөн: 40см, Өндөр: 56.5см, Хэмжээ: Хүрээ торго дээд өр-56,5 см доод өр-52 см	1125ДҮМ00131	-Монголын бурхны шашны урлаг I боть -Монголын музейн шилдэг бүтээлээс/ 525-р тал	Бүтээлийн дүрслэл: Амирлангуй дүрт Доржсэмба бурхны лагшингийн өнгө цагаан, 1 тэргүүн, 2 мутартай. Баруун мутартаа очир, зүүндээ хонх барин очир суудлаар саран дэвсгэрт бадам цэцгэн суурин дээр юүмийн хамт оршино. Юүм Чойенванчүгма хоёр мутартаа махир хутга, идээтэй гавал аяга барьж Доржсэмба бурхны хүзүүгээр тэвэрчээ. Хоёул таван дэлбээт титэм бүхий бурхдын таван зүйлийн чимэг зүүж, ногоон хадаг ороон, лагшингаас нь шар алтан гэрлэн туяа цацрах болой. Бүтээлийн дээд хэсгийн дүрслэл: Орой дээр нь алтан суварга, баруунаа бурхан багш хийгээд ханьцашгүй тарнийн ёсны догшин шүтээн Дэмчиг, зүүнээ Жигжид, Сандуй бурхад үүлэн дунд заларна. Голын хоёр талын дүрслэл: Доржсэмба бурхны хоёр талын зүүнд Аюуш, баруунд Гүнрэг бурхад байна. Бүтээлийн доод талын дүрслэл: Доод талын зүүнд Манал, баруунд Минтүг бурхад. Төв доор нь урсгал	Дэмжсэн

						<p>голоос урган гарсан цагаан бадам цэцгийн дэлбээнээ гадаад таван тахил болох толь, билба жимс, бийваа хөгжим, дун, хадаг тэргүүтэнг залжээ.</p> <p>Бүтээлийн өнгө: Бүтээлд ногоон, цагаан, улаан өнгө голлон, тэнгэрийн гурван чимэг нар, сар, үүл, газрын гурван чимэг уул, ус, мод зэргийг дүрсэлсэн байна. Бурхадын гэрлэн бие, чимэг зүүсгэл, бадны дэлбээ, гадаад тахил зэрэгт алт өргөсөн.</p> <p>Бүтээлийг хүрээлсэн торго: Уг бүтээлийг хүрэн өнгийн хээгүй торгоор хүрээлэн, зурагтай нийлсэн захад гараар томсон цагаан өнгийн нарийн зээг тавьж тойруулан чимсэн ба дөрвөн буландаа товгор угалзтай, алтан боронзон будаг бүхий модон жаазанд хийсэн байна</p>	
2	Дүншигийн 35-н бурхан	69.45.20	1	Өргөн: 1245см, Өндөр: 194см, Хэмжээ: Хүрээ торго: өн-270см, өр-1280см.	1125ДҮМ00108	<p>Ү.Дашням,Д.Гангаа. Торгон зураг., УБ.2000</p> <p>Энэхүү бүтээлийг Их хүрээний Тойсүмлингийн аймгийн Лувсандорж, Зоогийн аймгийн Хасгомбо нарын хар зургаар Их хүрээний Сангайн аймгийн үйлчид ХХ зууны эхэн үед өөрсдийн сайн дурын хөрөнгөөр бүтээсэн гэдэг. Энэ бүтээлийн өвөрмөц онцлог нь хөрөг дүрүүдээс гадна “Нэг харахад цэцэг навч эрээлсэн дэлгэр сайхан зуны улиралд Монгол орны онгон байгалийг санагдуулмаар үзэсгэлэн төгс болжээ” хэмээн Урлаг судлаач Дашням дүрджээ. “Дүншигийн 35</p>	Дэмжсэн

							бурхан” хэмээх энэхүү бүтээл нь XX зууны эхэн үеийн торгон дээр торгоор зээглэн маш нарийн урласан монголын сүрлэг зээгт наамлын гайхамшигт бүтээлүүдийн нэг юм	
НИЙТ 2 ДЭСИЙН 2 ШИРХЭГ								